

Шинэ техник, технологи, мэдээллийн технологийн хөгжлийг тэргүүлэх чиглэл болгож буй Германы туршлагыг судалж, энэ салбарт хамтран ажиллах нь чухал байна. Ер нь цаашид соёл, боловсрол, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг улам өргөтгөж, Германд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлыг чанарын шинэ шатанд гаргах шаардлагатай байна. Оюуны их нөөцтэй, боловсролын өндөр түвшинтэй, эдийн засаг, шинжлэх ухаан, техник өндөр хөгжсөн, угаасаа их хөдөлмөрч, хүмүүс нь бүтээх хөдөлмөрлөх онцгой чадвартай, амьдрах арга ухааныг сайн мэддэг уламжлалтай, өндөр зохион байгуулалттай, аливаа хууль дүрэм зааврыг аль ч насны хүмүүс нь чанд мөрддөг уламжлалтай, эдийн засаг, санхүүгийн асар их нөөц бүхий Герман орноос суралцах зүйл их бий.

### **Монгол улсын Цэргийн Яамнаас Герман улсын худалдааны пүүстэй холбоо тогтоох гэсэн нэгэн оролдлого**

*Г.Дашням /Ph.D ШУА-ийн  
Түүхийн хүрээлэнгийн ЭША/  
И.Будбаяр /аспирант/*

XIX зууны эцэс, XX зууны эхээр Монгол орны зах зээлд Хятад, Хаант Оросын худалдаа үйлдвэрийн капиталын зэрэгцээ Герман, Англи, Америк зэрэг тэргүүний хөгжилтэй орнуудын капитал нэвтэрч Монголын зах зээл дээр өрсөлдөх болжээ.

1921 оны 2 дугаар сард Барон Унгерний удирдсан цагаантны цэрэг монгол цэргийн тусламжтайгаар Нийслэл Хүрээг гамин цэргээс чөлөөлсний дараа өөрийн цэргийн нөөц бэлтгэлийг хангахын тулд Монгол улсын санхүүгийн чадавхийг сэргээх зорилгоор нилээд олон төрлийн арга хэмжээ авсны дотор Монгол нутагт байсан гадаадын пүүс, эд боловсруулах үйлдвэрүүдээс татвар хураах дүрмийг зохиолгон, Нийслэл Хүрээ зэрэг газрын гадаадын пүүсүүдийн тоо, орлогыг байцаалгасан. 1921 оны цагаан сард явуулсан уг тооллогын баримтаас үзвэл, 1920-1921 оны заагт Нийслэл Хүрээнд нийт 454 худалдааны пүүс ажиллаж байснаас 408-нь Хятад улсын харъяат, 37-нь Орос улсын харъяат, 9-нь бусад улсын харъяат пүүс байв. Эдгээр пүүсийн жилд гүйлгэсэн мөнгөний хэмжээ нь янчаанаар бодвол, Хятад улсын харъяат пүүснийх 6.868.220, Орос улсын харъяат пүүснийх 499000, бусад улсын пүүснийх 3.440.000 болж

байжээ.<sup>1</sup> Эндээс үзвэл, нэг жилд дунджаар Хятад улсын харъяат худалдааны нэг пүүс нь 14343 янчааны, Орос улсын харъяат худалдааны нэг пүүс нь 13486 янчааны, бусад улсын харъяат худалдааны нэг пүүс нь 382222 янчааны гүйлгээ тус тус хийж байсан аж. Энэ нь бусад улсын харъяат хэмээн нэрлэгдсэн Нийслэл Хүрээнд дэх худалдааны нэг пүүс нь жилд Хятад улсын харъяат нэг пүүснээс 27,3 дахин, Орос улсын харъяат худалдааны нэг пүүснээс 28,3 дахин их худалдааны гүйлгээ хийж байсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл, бусад улсуудын хэмээн тэмдэглэгдсэн худалдааны пүүсүүд нь тооны хувьд цөөн боловч хүчин чадал, худалдааны гүйлгээний хэмжээний хувьд Хятад, Оросын пүүсүүдээс ихээхэн давуу байжээ.

1921 онд үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа Ардын засгийн газар, түүний зарим зүтгэлтнүүдээс нийгмийн байгуулал, засаг төрийн хэлбэр, үзэл суртлын ялгааг үл харгалзан ЗОУ-аас гадна дэлхийн тэргүүний хөгжилтэй улс орнуудын пүүсүүдтэй эдийн засгийн хэлхээ холбоо тогтоож, хамтран ажиллах бодлого баримтлах болов. Үүний нэгэн баримт нь, 1922 оны хавар Цэргийн Яамны тэргүүн сайд, бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар нараас Герман улсын харъяат Юэнь Фунг Трейдинг хоршоо хэмээх пүүстэй худалдааны гэрээ байгуулан хамтран ажиллах гэсэн нэгэн оролдлого юм.

1922 оны хавар Монгол улсын Цэргийн Яамнаас Герман улсын харъяат Юэнь Фунг Трейдинг пүүстэй худалдааны гэрээ байгуулан, цэргийн хувцас үйлдэх бараа, түүхий эд худалдан авах ажлыг сэдсэн байна. Чингээд 1922 оны гуравдугаар сарын 28-нд Нийслэл Хүрээнд дэх тус пүүсийн төлөөлөгч Хуго Мендаль, Луппа Герасимович Козулин нарт өөрийн пүүсээр дамжуулан дор дурдсан 9 нэр төрлийн барааг Тяньжингээс Нийслэл Хүрээнд маш яаралтай хүргүүлэхийг хүсч Цэргийн Яамны сайд, Бүх Цэргийн жанжин Д.Сүхбаатар, Цэргийн Яамны эрхэлсэн түшмэл бөгөөд штабын дарга Хува нарын гарын үсэг бүхий албан бичиг илгээжээ.<sup>2</sup>

Захиалсан барааг дурдвал,

- 1.Хамгаалан далдлах бор ногоон өнгийн цэмбэ 1000 аршин (1 аршин=0.75 м=750 м)
- 2.Дотуур цагаан өмдний цагаан янбуу 20000 аршин (15000 м)
3. №20-ийн цагаан утас 10000 булуу
4. №20-ийн хар утас 20000 булуу
5. Гутлын ул хийх америк шир 100 пуд буюу пүү (1600 кг)
6. Даавууны өнгөлөн далдах будаг 2 пуд (32 кг)

7. Савхины өнгөлөн далдлах будаг 2 пуд (32 кг)
8. Өнгөлөн далдах өнгөтэй брезент маягийн өрмөг даавуу 5000 аршин (3750 м)
9. Өнгөлөн далдлах өнгө бүхий гадуур цамцны нимгэн даавуу 10000 аршин (7500 м) болно.

Эдгээр бараа нь дулаан цаг буюу зун цагийн цэргийн хувцас үйлдэхэд зориулагдсан тухайн үедээ нилээд их хэмжээний бөөнөөр худалдан авах бараа байлаа. Мөн Цэргийн Яамнаас уг худалдааг хийхэд өөрийн талаас хариуцан гүйцэтгэх үүрэг, үзүүлэх хөнгөлөлтийг явуулсан бичигтээ заасан байна. Үүнд: Нэгд. Ирүүлсэн барааг хүлээн авсан даруй үнийг зарцуулсан хөрөнгийн үнэ дээр 10 хувийн нэмэгдэлтэйгээр олгох, тооцооны 1/3-ийг биллоноор /Зоос цутгахад хэрэглэгддэг сайн чанарын цалин цагаан мөнгө/, 2/3-ыг доллараар төлөх, хоёрт. Захиалсан барааг Чуулалт Хаалганаас Нийслэл Хүрээнд тээвэрлэн авчрах тээврийн хөлсийг тогтсон үнэ ханшаар нь төлж гүйцэтгэх, гуравт. Монгол улс дахь гаалийн татварыг хариуцахаар заажээ.<sup>3</sup>

Юэнь Фунг Трейдинг пүүсийн төлөөлөгчид Цэргийн Яамны эл ашигтай саналыг тэр даруйд нь хүлээн авч, харилцан хэлэлцээний дүнд хэлэлцэн батлах гэрээний эх төсөл бэлэн болсон аж.

Монгол улсын Цэргийн Яамыг төлөөлөн тус яамны тэргүүн сайд Д.Сүхбаатар, Бүх цэргийн бэлтгэлийн хэлтсийн эрхэлсэн түшмэл Б.Баянчуулган, Герман улсын харъяат Юэнь Фунг Трейдинг хоршоо хэмээх пүүсийг төлөөлөн тус пүүсийн төлөөлөгч Хуго Мендаль, Луппа Герасимович Козулин нар гарын үсэг зурахаар төлөвлөсөн 11 зүйл бүхий энэ гэрээний төсөлд хоёр талын харилцан хүлээх эрх, үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Монгол улсын Цэргийн Яам нь Юэнь Фунг Трейдинг пүүс захиалгат барааг худалдан авах газарт өөрийн төлөөлөгчийг илгээн хяналт тавих эрхийг эдлэхийн хамт дараах үүргийг хүлээжээ. Дурдвал, нэгд. Захиалсан бараанаас Нийслэл Хүрээнд хураах гаалийн татварыг өөртөө хүлээх, хоёрт. Захиалсан барааг Чуулалт Хаалганаас Нийслэл Хүрээнд тээн ирүүлэх тээврийн зардлыг тухайн үед Нийслэл Хүрээнд ачаа тээвэрлэх жингийн хөлс өртөгтэй хирцүүлэн төлөх, гуравт. Захиалсан барааны заримыг буюу бүрнээ хүлээн авсан тухайд зохих үнийг даруй гаргаж төлөхдөө захисан барааны үнийг хоёр этгээдээс хэлэлцэн тохирч мөнгөөр буюу түүхий эд, үнэг, хэрэм, шилүүс, тарвага зэрэг ангийн арьс ба тэмээний ноосоор Нийслэл Хүрээнд төлөх, тийнхүү

төлөхдөө гэрээ бичгийг батлах үед Нийслэл Хүрээнд тэдгээр түүхий эдийн үнэ ямар байсныг Монгол улсын зохих албаны газраас батлан тодорхойлуулж гэрээнд хавсаргасныг үндэс болгохоор заажээ.<sup>4</sup>

Германы нэр дурдсан пүүс нь гэрээний төсөлд дор дурдсан эрх, үүргийг хүлээсэн байна. Үүнд: нэгд, Захиалгат барааг ханган нийлүүлэх завод, боловсруулах үйлдвэр, түүнээс худалдан авсан барааны жинхэнэ үнэ дээр Нийслэл Хүрээнд хураах гаалиас бусад гарсан бүх зардлын 1/10 хувийг ашиг болгон нэмэгдүүлж авах, хоёрт, Нийслэл Хүрээнээс өөр газар хураалгах гаалийн зарлага, сүйтгэлийг өөртөө хүлээх, гуравт, Захисан барааны үнэ нь тус пүүсийн бараа үнэлэн авах тухайн газрын зах зээлийн үнээс ихгүй байх, үнэлж авсан барааны жинхэнэ үнийг тодорхойлсон счөт хэмээх хуудсыг Герман улсын элчин сайдын газар буюу консулын төлөөлөгчөөр батлуулсан байх, дөрөвт, Пүүс нь Монгол улсын Цэргийн Яамны төлөөний хүнд захиалгат барааг ямар пүүснээс үнэлэн авсныг заан өгөх, тавд, Захиалгат барааг гэрээнд гарын үсэг зурж баталснаас хойш гурван сарын дотор нийлүүлэх, барааг нийлүүлэхдээ хэсэг хэсгээр нь хуваан олгож болох боловч гэрээнд гарын үсэг зурж баталснаас хойш нэгдүгээр хэсгийг нэг сар хагасаас өнгөрүүлэхгүй, хоёрдугаар хэсгийг гурван сараас өнгөрүүлэлгүй Нийслэл Хүрээнд ирүүлж, Цэргийн Яаманд олгох, зургаад, Захиалгат барааны чанарыг шалгахдаа гэрээ байгуулагч хоёр талаас тус бүр нэгжгээд хүнийг томилон гаргаж, тусгай комиссоор үзүүлж хүлээлцүүлэх, хэрэв барааны дотроос шаардлага хангахгүй бараа гарч Цэргийн Яам авахаас татгалзвал тэдгээрийг счөт хэмээх хуудаснаас хасан гаргаж, Чуулалт Хаалганаас Нийслэл Хүрээнээ тээн авчирсан үнийг Хүрээний газарт хураалгасан гаалийн хамтаар биедээ хүлээх, долоод, Замын зуур бараа зүйл гэмтвэл сүйтгэлийг өөртөө хариуцах, наймд, Хэрэв тээн авчирсан бараа нь шаардлага хангахгүйгээс Цэргийн Яам авахаас татгалзах буюу захиалгат барааг гэрээ бичиг баталснаас хойш гурван сарын дотор гүйцэтгэн ирүүлж эс чадвал захиалгат барааны хагас үнийг Цэргийн Яаманд торгууль болгон төлөх, жич, тээн явуулсан бараа нь ус, салхи, хулгай дээрмийн аюул болон байлдааны хэрэг явдлаас үүдэн замын зуур саатвал тогтоосон хугацааны дотор эс гүйцэтгэсэн хариуцлагыг үл хүлээнэ хэмээн заажээ.<sup>5</sup>

Гэрээний төслийн төгсгөлд, гэрээ бичгийг орос, монгол үсгээр 3 хувь үйлдэж Цэргийн Яам, Юэнь Фунг Трейдинг хоршоо хэмээх пүүсний Тяньжин, Нийслэл Хүрээн дэх салбарт тус бүр нэг нэг хувийг хадгална хэмээн заажээ.

1922 оны 4 дүгээр сарын 1-нд Бүх Цэргийн Зөвлөлийн тэргүүлэгч Э.Ринчино Ардын засгийн газарт явуулсан бичигт, “Саяхан Германы Юэнь Фунг Трейдинг пүүснээс олон цэргийн хувцас хийх бараа зүйлийг худалдан авахаар Цэргийн Яамнаас хэлэлцэн гэрээ бичгийг тогтоогоод, Зөвлөлийн тэргүүлэгч надад үзүүлэхээр ирсэн”<sup>6</sup> хэмээн тэмдэглэснээс үзэхэд гэрээний энэ төслийг хоёр талын нэр дурдсан хүмүүс гарын үсэг зурж үзэглэн баталсан бололтой юм. Гэвч тодорхой шалтгааны улмаас уг гэрээ хэрэгжиж биелээгүй ажээ.

БЦЗ-ийн тэргүүлэгч Э.Ринчино Цэргийн Яамнаас Юэнь Фунг Трейдинг пүүсэнд явуулсан бичиг болон энэхүү гэрээ, эс бөгөөс гэрээний төсөлтэй танилцаад дэмжин, Сангийн Яамны түшмэл Бутины саналыг авахаар Цэргийн Яамнаас дээрх пүүсэнд явуулсан бичгийг илгээжээ.

Бутин Цэргийн Яамнаас Юэнь Фунг Трейдинг компанид явуулсан бичигтэй танилцаад, 1922 оны 3 дугаар сарын 30-нд Бүх Цэргийн Зөвлөлийн тэргүүлэгчид саналаа бичиж ирүүлжээ. Саналд дээрх гэрээ нь “зүйд эс нийлэлцэх хэлтгий хэлэлцээ” хэмээн нэрлээд, “энэхүү хэлэлцээ бол Монголын Засгийн газраас хүлээн зөвшөөрч огт болохгүй. Үүнийг хэлэлцэн тогтооход худалдааны явдал ба гэрээ байгуулах хууль ёс мэдэх хүмүүс эс оролцсон мэт” хэмээн эрс буруушаан шүүмжлээд түүнийхээ нотолгоо болгон хэд хэдэн шалтгааныг дурджээ. Тухайлбал, захисан бараа зүйлийн үнийг эс тодорхойлсон, бараа зүйлийг төдийд авчран тушаана хэмээн тогтсон хугацаа байхгүй учир тэрхүү барааны ирэх нь Цэргийн газраас чухал зүйлийг хэрэглэх цагт эс тушаан оройтож саатуулж болзошгүй, хугацаанд хэмээх зэрэг үг оруулсан нь хугацаа тогтоосон бус, үүнийг баримтлан хэрэв бараа хэрэглэх цагт авчран тушааж эс чадвал түүний гэмийг Цэргийн Яам өөрөө хүлээх болно, захиж авчруулсан бараа зүйлийн үнэ өртгийн 1/3-ийг цагаан мөнгөөр, үлдэх 2/3 хувийг янчаанаар төлөхөөр хэлэлцсэн нь зах зээл дээр бусад мөнгө зоосны үнийг бууруулж элдэв асуудал гарахад хүргэнэ, цэргийн хэрэглэх бор ногоон өнгийн цэмбэ Сангийн Яамнаа буй бөгөөд гутлын ул хийх америк арьсыг хямд үнээр Оросоос авч болно, сураглаж үзвэл, Козулин хэмээгч сайн худалдаачны тоонд орж чадаагүй мэт хүн тул тэдгээр Козулин ба Мендаль хэмээх хоёр хүмүүс Герман улсын пүүсийн төлөөлөгч болсон нь магадлахад бэрхтэй ажгуу<sup>7</sup> гэжээ. Бутины саналд, уг гэрээг батлан тогтооход чухлаар холбогдох зөв зүйтэй саналууд байгаа боловч уг саналын хуудас нь гэрээ байгуулахад бодитойгоор туслахыг эрмэлзсэнгүй, нэг талыг баримтлан гэрээг шууд зогсооход чиглэгджээ.

Мөн Бутин уг бичигтээ, Цэргийн Яамны гадаад худалдааны эрхийг хязгаарлахыг оролдож, "ихээхэн худалдааны гэрээ ба хэлэлцээг ялангуяа гадаадын пүүс лүгээ хийх хэлэлцээг Сангийн Яамнаас хэлэлцэн тогтоовол зохино... Цэргийн Зөвлөл цэргийн хэргийг эрхлэвэл зохих мэт надад санагдахын дээр Цэргийн Зөвлөлийн гишүүн нар худалдааны явдалд боловсорсонгүй ч байж болох"<sup>8</sup> хэмээн дайржээ.

БЦЗ-ийн тэргүүлэгч Э.Ринчинод Сангийн Яамны зөвлөх Бутины санал огтхон ч таалагдсангүй тул харилцан үл ойлголцох байдал бий болж, нөгөөдөр нь буюу 1922 оны 4 дүгээр сарын 1-нд Засгийн газарт Бутины саналыг Германы пүүстэй тогтоосон гэрээ бичгийн хамт илгээж, Бутин юуны учир тийнхүү бичих болсны учрыг байцаан шийтгэх, Германы Юэнь Фунг Трейдинг пүүснээс цэргийн хувцас хийлгэх, бараа худалдан авахаар Цэргийн Яамнаас хэлэлцэн тогтоосон гэрээ бичиг болох, эсэхийг батлан тогтоох, хэрэв үл болох аваас дурдсан барааг хэрхэн хэлэлцэж авбаас зохихыг нэн даруйхан тогтоож, хойш хариу ирүүлмү хэмээн бичжээ.<sup>9</sup>

Засгийн газар уг бичигтэй танилцаад, Цэрэг, Сангийн яам хамтран нарийвчлан хэлэлцэн тогтоохыг даалгасан байна. Тэр дагуу тус хоёр яам хамтран шүүн хэлэлцээд, Германы нэр дээр дурдсан пүүс байгуулсан гэрээнд уг бараа юмны үнэ, авчран хүлээлгэн өгөх хугацааг тодорхой заагаагүйн дээр тээврийн хөлс, Нийслэл Хүрээнд хураалгах гаалийг Цэргийн Яам хариуцах нь чирэгдэл сүйтгэл үлэмж бөгөөд уг барааг тэдний пүүсэд захиж авчруулах үнэ нь Нийслэл Хүрээнээс бусад газраас худалдан авах үнээс ашиггүй мэт тул уг барааг Юэнь Фунг Трейдинг хоршоо пүүсэд захиж авчруулах явдлыг бүрмөсөн зогсоож, түүгээрээ Америкийн нэгэн пүүсэнд түшмэл томилон одуулж барааных нь яс чанар үнийг хэлэлцүүлэх тухайг үзэж гүйцэтгэхээр тогтож, тэр тухайгаа Засгийн газарт 1922 оны 4 дүгээр сарын 8-нд мэдэгдэж, заан тогтоохыг эржээ<sup>10</sup> Засгийн газар тэрхүү албан бичигтэй танилцаад, "энэ гэрээг харъяат хоёр яамнаас уул төлөвлөсөн ёсоор нэн даруй түшмэдийг томилон илгээж, тэрхүү пүүсийн эд барааг нарийвчлан хянан үзээд яс, өнгө тохирвоос үнийг хэлэлцэн худалдан авч гүйцэтгэвээс зохино."<sup>11</sup> гэсэн хариу өгчээ.

Байдал ийнхүү эргэсэнд Юэнь Фунг Трейдинг пүүс уг хэлэлцээнээс татгалзахаар шийджээ. Уг пүүснээс 1922 оны 8 дугаар сарын 4-нд Монгол улсын Бүх Цэргийн жанжин Д.Сүхбаатарт ирүүлсэн бичигт, "Монгол цэргийн цагаан хэрэглэлд зориулах эд

барааг юуны өмнө явуулна уу хэмээсэн таны хүсэлтийг штабын орлогч дарга Меркуловоор дамжуулан энд хүлээн аваад бид өөрийн зүгээс Тяньжин дахь салбартаа нэн даруй утас цохисонд, Монголын худалдааны хоршооны төлөөлөгчидтэй одоо хүртэл хэлхээ холбоо тогтоосон зүйлгүй байгаа гэсэн хариуг сая хүлээн авав. Ингэхлээр бид таны хүсэлтийг биелүүлж чадахгүй болсондоо нэн их харамсаж байна. Энэхүү бичгийн хуулбарыг Монголын харилцан туслалцах хоршоонд явуулав. Гүнээ хүндэтгэн ёсолсон Мендаль”<sup>12</sup> гэжээ.

Ийнхүү Монгол улсын Цэргийн Яамны Герман улсын худалдааны пүүстэй холбоо тогтоон, худалдааны гэрээ байгуулах гэсэн нэгэн оролдлого талаар өнгөрчээ Цэргийн яам, Сангийн Яамнаас Америк улсын пүүстэй дээрх асуудлаар худалдааны гэрээ байгуулсан, эсэхийг магадлан байцаах баримт бидний гарт хараахан алга байна.

Цэргийн Яамнаас Герман улсын Юэнь Фунг Трейдинг хоршоо пүүстэй байгуулсан гэрээ нь Монгол улсын Цэргийн Яам, түүний сайд Д.Сүхбаатар нараас Өрнөдийн пүүсийн төлөөлөгчтэй гэрээ тогтоосон анхны хэлэлцээний нэг байжээ. Гэвч уг гэрээ нь хэрэгжин биелэлээ олж чадалгүй цуцлагджээ. Дээрх гэрээтэй холбогдсон баримтаас үзвэл, Цэргийн Яам, түүний сайд Бүх Цэргийн жанжин Д.Сүхбаатар нар ЗОУ-тай цэрэг, улс төр, эдийн засгийн салбарт нягт хамтран ажиллахын зэрэгцээ гуравдагч орон, тухайлбал, тухайн үедээ тэргүүний хөгжилтэй улсын тоонд зүй ёсоор тооцогдож байсан Герман улсын худалдааны пүүстэй эдийн засгийн хэлхээ холбоо тогтоохыг оролдож байсан нь тодорхой байна

### Ишлэл

1. “Ар Монгол дахь Хятадын худалдаа мөнгө хүүлэл” УБ.,1987
2. Д.Сүхбаатар /баримт бичгийн эмхтгэл/ УБ., 2003 тал 114 дүгээр тал
3. Мөн тэнд.
4. МАХН-ын Төв архив Ф-21, Д-1, ХН-68.
5. Мөн тэнд.
6. МУУТА. Ф-1, Д-1, ХН-89, Х.127.
7. МАХН-ын ТА. Ф-12, Д-1, ХН-175, Х.10-11, орос эх нь Х.12-т буй.
8. Мөн тэнд.
9. МУУТА. Ф-1, Д-1, ХН-89, Х.127
10. МУУТА. Ф-1, Д-1, ХН-89, Х.159.
11. Мөн тэнд.
12. Д.Сүхбаатар /баримт бичгийн эмхтгэл/ УБ., 2003 он, 234-р тал